

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/12-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Ж.Цогт
Утас: 70362442 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..	10-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15-17
4. Аудитын тайлан.....	17-25
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17-18
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18-19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19-20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. Аудитын илрүүлэлт	20-24
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль, орчин аялал жуулчлалын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗЗНДНТУ	Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № СЭА-2024/12-НА-СТА - ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар 8,992,277.9 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 8,317,100.7 төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 92.5 хувьтай тайлагнагдсан бөгөөд батлагдсан төсвийг 675,177.2 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

ЗДТГ нь төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг буюу өөрийн үйл ажиллагааны орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр багаар буюу 46,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр
СЭА-2024/12-НА-СТА-ТТЗ

төлөвлөгөөнөөс давсан 17,884.5 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд авч зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,279,577.0	1,855,297.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,223,871.7	707,198.3
33	АВЛАГА	966,040.4	1,047,168.8
35	БАРАА МАТЕРИАЛ	89,664.9	100,930.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,455,183.0	1,902,581.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,455,183.0	1,902,581.5
39100	Газар	-	96,123.0
39200	Биет хөрөнгө	1,330,822.2	1,682,553.4
39300	Биет бус хөрөнгө	124,360.7	123,905.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,734,759.9	3,757,879.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,779.7	6,876.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,779.7	6,876.8
41300	Өглөг	6,779.7	6,876.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,727,980.2	3,751,002.5
51	Засгийн газрын хувь оролцоо	3,727,980.2	3,751,002.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	324,958.0	324,958.0
51200	Хуримтлагдсан үр дүн	3,310,370.9	3,333,393.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,651.3	92,651.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,734,759.9	3,757,879.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	14,055,346.4	10,539,642.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	6,848,527.7	8,893,658.0
110	Орлогын албан татвар	6,348,318.5	8,383,821.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,348,318.5	8,889,474.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(505,653.3)
113	Хөрөнгийн албан татвар	208,446.5	219,507.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	291,762.7	290,329.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,076,012.8	803,852.2
120	Нийтлэг татварын бус орлого	1,076,012.8	803,852.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,130,806.0	842,132.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,715,315.5	9,617,785.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,651,320.1	7,990,419.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,515,314.2	5,425,981.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,116,479.2	1,190,224.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,294.0	146,772.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,581,949.5	75,700.4
2104	Хангамж, бараа материалын зардал	59,565.4	74,234.4
2105	Нормативт зардал	700.0	900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	270,912.1	90,358.0
2107	Томилолт, зочны зардал	6,742.8	16,447.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	894,511.2	3,205,093.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	448,159.9	626,250.4
212	ТАТААС	264,978.0	109,844.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,871,027.9	2,454,594.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,995.4	1,627,365.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,340,030.9	921,857.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,214.1	480.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	27,050,752.8	899,316.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(24,709,507.8)	23,022.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,814,960.9	-	28,814,960.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(377,473.0)	-	(377,473.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	28,437,487.9	-	28,437,487.9
9	Тайлант үеийн үр дүн	(24,709,507.8)	-	(24,709,507.8)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,727,980.2	-	3,727,980.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,727,980.2	-	3,727,980.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,727,980.2	-	3,727,980.2
19	Тайлант үеийн үр дүн	23,022.3	-	23,022.3
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	3,751,002.5	-	3,751,002.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,218,801.9	10,304,421.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	6,848,527.7	8,893,658.0
110	Орлогын албан татвар	6,348,318.5	8,383,821.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,348,318.5	8,889,474.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(505,653.3)
113	Хөрөнгийн албан татвар	208,446.5	219,507.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	291,762.7	290,329.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	173,205.4	159,630.9
1181	Газрын төлбөр	105,252.3	130,588.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	13,304.9	109.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	597,759.4	568,631.1
120	Нийтлэг татварын бус орлого	597,759.4	568,631.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	772,514.8	842,132.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,378,293.0	7,830,322.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,378,293.0	7,830,322.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,601,237.3	5,265,883.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,115,900.1	1,189,860.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,395.1	146,510.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,674,745.4	75,700.4
2104	Хангамж, бараа материалын зардал	59,085.4	76,984.4
2105	Нормативт зардал	700.0	900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	296,982.5	91,260.0
2107	Томилолт, зочны зардал	6,431.4	16,447.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	898,936.0	3,206,531.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	411,061.3	461,688.9
212	ТАТААС	264,978.0	109,844.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,512,077.7	2,454,594.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,840,508.8	2,474,099.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,091,120.6	2,790,772.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,091,120.6	2,790,772.9
2200	Дотоод эх үүсвэрээр	1,091,120.6	2,790,772.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,091,120.6)	(2,790,772.9)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(133,278.0)	(200,000.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	133,278.0	200,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	616,110.2	(516,673.4)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	607,761.5	1,223,871.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,223,871.7	707,198.3

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,992,277.9	8,317,100.7	(675,177.2)	92.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,656,273.3	5,399,747.8	(256,525.5)	95.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,528,818.9	5,272,293.4	(256,525.5)	95.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,238,287.6	1,189,860.0	(48,427.6)	96.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,536.6	146,510.6	(8,026.0)	94.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,042,468.3	1,873,361.4	(169,106.9)	91.7
2104	Хангамж, бараа материалын зардал	77,258.7	75,184.4	(2,074.3)	97.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	346,543.0	344,964.9	(1,578.1)	99.5
2107	Томилолт, зочны зардал	16,460.0	16,447.6	(12.4)	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,221,383.0	1,208,586.0	(12,797.0)	99.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	431,881.7	417,378.7	(14,503.0)	96.6
212	ТАТААС	109,844.4	109,844.4	-	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	109,844.4	109,844.4	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,610.0	17,610.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,610.0	17,610.0	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,136,004.6	2,717,352.9	(418,651.7)	86.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.0	200,000.0	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,997,277.9	8,126,228.9	(871,049.0)	90.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,688,576.0	7,979,611.0	291,035.0	103.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,303,701.9	146,617.9	(1,157,084.0)	11.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	430,835.5	430,835.5	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	239,963.7	239,963.7	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,040.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,040.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,010.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,800.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800.0
2105	Нормативт зардал	900.0
210502	Хоол, хүнс	900.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,310.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,310.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	29.8
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	29.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	20,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	67,040.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,040.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,750.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,405.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,884.5

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хууль тогтоомж төр засгийн бусад шийдвэрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн оновчтой бодлого зохицуулалтаар ханган төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэн, Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэн ажиллах” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, аймаг, сумын ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Аймгийн “Бүтээн байгуулалт, нийгмийн хөгжлийг дэмжих жил”-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнах, үр дүнг тооцох,
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах,
- Эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулах,
- Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэнийг төлөвшүүлэх,
- Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр ТБОНӨХБАҮХАТ хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сүхбаатар сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан *“Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”*- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан *“Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”*-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,119.4 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,223,871.7	707,198.3	(516,673.4)
Авлага	966,040.4	1,047,168.8	81,128.5
Бараа материал	89,664.8	100,930.6	11,265.8
Үндсэн хөрөнгө	1,455,183.0	1,902,581.5	447,398.5
Нийт хөрөнгө	3,734,759.9	3,757,879.3	23,119.4
Өр төлбөр	6,779.7	6,876.8	97.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,727,980.2	3,751,002.5	23,022.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,734,759.9	3,757,879.3	23,119.3

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансад бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 707,198.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 516,373.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	1,223,871.7	707,198.3	(516,673.4)
Төгрөг	1,223,871.7	707,198.3	(516,673.4)
Төрийн сангийн харилцах	1,223,871.7	707,198.3	(516,673.4)
Арилжааны банк дахь харилцах	-	-	
Дүн	1,223,871.7	707,198.3	(516,673.4)

Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансанд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 467,234.6 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 178,796.9 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 61,166.8 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,047,168.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 81,128.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	845.9	501.9	(344.0)
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	
Байгууллагаас авах авлага	25,774.1	19,655.6	(6,088.5)
Хувь хүмүүсээс авах авлага	939,420.3	1,027,010.8	87,590.5

Дүн	966,040.3	1,047,168.8	81,128.5
-----	-----------	-------------	----------

Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай /2013-2015 онуудад үүссэн итгэлийн зээл, татварын хөнгөлөлтийн авлага гэх мэт/ 9,319.0 мянган төгрөгийн авлага байгаагаас орон нутгийн ерөнхий орлогын 2,695.3 мянган төгрөг, ЗДТГ-ын 6,623.7 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 97.7 хувь буюу 1,022,797.9 мянган төгрөгийг ХХС-ийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

Насжилт өндөртэй /3-аас дээш жил/ ХХС-ийн зээлийн 761,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандаж, 103 иргэний нийт 761,000.0 мянган төгрөгийн нэхэмжлэлийг хүргүүлж, 5 иргэнийг Шүүхийн шийдвэрийн дагуу эрэн сурвалжлах ажил хийгдэж байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 100,930.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,265.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	36,886.8	39,096.9	2,210.1
Тусгай зориулалттай материал	36,886.8	39,096.9	2,210.1
Эм боох материал	-	-	-
Хангамжийн материал	45,778.1	54,833.7	9,055.7
Бичиг хэргийн материал	942.0	2,027.6	1,085.6
Аж ахуйн материал	33,073.2	35,350.4	2,277.2
Сэлбэг хэрэгсэл	1,914.0	1,912.0	(2.0)
Түлш, шатах тослох материал	-	5,000.0	5,000.0
Барилгын засварын материал	-	-	-
Бусад хангамжийн материал	16,848.9	17,543.8	7,694.9
Мал амьтад	-	-	-
Дүн	89,664.8	100,930.6	11,265.8

Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оныхоос 11,265.8 мянган төгрөгөөр өссөн нь 215,023.6 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч 204,052.8 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,902,581.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 447,398.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	-	96,123.0	96,123.0

Биет хөрөнгө	1,330,822.3	1,682,553.5	351,731.2
Барилга, байгууламж, орон сууц	1,008,493.1	1,138,182.8	129,689.8
Хуримтлагдсан элэгдэл	(96,639.8)	(152,212.6)	(55,572.9)
Авто-тээврийн хэрэгсэл	165,395.8	165,395.8	-
Хуримтлагдсан элэгдэл	(86,834.1)	(100,378.5)	(13,544.4)
Машин тоног төхөөрөмж	153,403.6	230,832.7	77,429.1
Хуримтлагдсан элэгдэл	(49,008.0)	(80,567.1)	(31,559.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	114,564.1	140,049.1	25,485.0
Хуримтлагдсан элэгдэл	(60,539.8)	(71,380.7)	(10,840.9)
Зам гүүрийн байгууламж	145,412.4	145,412.4	-
Хуримтлагдсан элэгдэл	(58,854.2)	(60,255.6)	(1,401.4)
Бусад үндсэн хөрөнгө	152,435.2	441,548.6	289,113.4
Хуримтлагдсан элэгдэл	(57,071.0)	(114,138.3)	(57,067.2)
Ном	65.0	65.0	-
Биет бус хөрөнгө	124,360.7	123,905.0	(455.7)
Программ хангамж	2,682.5	2,682.5	-
Хуримтлагдсан элэгдэл	(1,889.8)	(2,345.5)	(455.7)
Бусад биет бус хөрөнгө	123,568.0	123,568.0	-
Дүн	1,455,183.0	1,902,581.5	447,398.5

Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 447,398.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 50,670.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, сумын төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-аар хэрэгжүүлсэн 99,766.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 96,123.0 мянган төгрөгийн газрыг орлогод авч, 238,841.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан /ХХААЯ-наас 192,847.4 мянган төгрөгийн 35 ширхэг хүлэмж, усны нөөцийн сав, аймгийн ЗДТГ-аас 19,494.1 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Ж.Эрдэнэбат гишүүнээс 10,000.0 мянган төгрөгийн тавилга, ДЗОУБ-аас 11,500.0 мянган төгрөгийн тоглоомын талбай, аймгийн БОАЖГ-аас 5,000.0 мянган төгрөгийн самбар/ зэрэг нийт 485,400.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,757,879.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 23,119.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	324,958.0	324,958.0	-
Хуримтлагдсан үр дүн	3,310,370.9	3,333,393.2	23,022.3
Өмнөх үеийн үр дүн	28,019,878.7	3,310,370.9	(24,709,507.8)
Тайлант үеийн үр дүн	(24,709,507.7)	23,022.6	24,732,530.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,651.3	92,651.3	-
Дүн	3,734,759.9	3,757,879.3	23,119.4

Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 23,119.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Сүхбаатар сумын ИТХ-ын “2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 2023 оны 08 дугаар сарын 09–ний өдрийн 79 дүгээр дүгээр тогтоолоор 9,010,467.6 мянган төгрөгийн татварын орлого, 340,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого зэрэг нийт 9,350,467.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 9,823,363.5 төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 105.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	9,010,467.6	9,399,311.2	388,843.6	104.3
Хувь хүний орлогын албан татвар	7,907,297.6	8,023,677.2	116,379.6	101.5
Үйл ажиллагааны орлого	40,000.0	215,760.9	175,760.9	539.4
Хөрөнгийн орлого	375,000.0	377,546.6	2,546.6	100.7
Хөрөнгө борлуулсны орлого	200,000.0	272,489.6	72,489.6	136.2
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	140,000.0	198,770.1	58,770.1	142.0
Малын тоо толгойн албан татвар	36,290.0	16,507.5	(19,782.5)	45.5
Бууны албан татвар	5,500.0	4,230.0	(1,270.0)	76.9
Улсын тэмдэгтийн хураамж	105,000.0	65,577.5	(39,422.5)	62.5
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000.0	5.0	(995.0)	0.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	120,000.0	94,048.3	(25,951.7)	78.4
Газрын дуудлага худалдааны орлого	80,000.0	130,588.9	50,588.9	163.2
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	150.0		(150.0)	-
Байгалийн ургамал ашигласны төлбөр	30.0	35.0	5.0	116.7
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	200.0	71.3	(128.7)	35.3
Татварын бус орлого	340,000.0	424,052.3	84,052.3	124.7
Хүү, торгуулийн орлого	280,000.0	377,567.2	97,567.2	134.8
Бусад орлого	60,000.0	46,485.1	(13,514.9)	77.5
Нийт дүн	9,350,467.6	9,823,363.5	472,895.9	105.1

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд:

- ХХОАТ-ын орлого 116,379.6 мянган төгрөгөөр,
- Үйл ажиллагааны орлого 175,760.9 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн орлого 2,546.6 мянган төгрөгөөр,
- Хөрөнгө борлуулсны орлого 72,849.6 мянган төгрөгөөр,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 58,770.1 мянган төгрөгөөр,
Газрын төлбөр болон дуудлага худалдааны орлого 50,588.9 мянган төгрөгөөр,
- Хүү, торгуулийн орлого 97,567.2 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол
- Малын тоо толгойн албан татвар 19,782.5 мянган төгрөгөөр,

- Бууны албан татвар 1,270.0 мянган төгрөгөөр,
- Улсын тэмдэгтийн хураамж 39,422.5 мянган төгрөгөөр,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 25,951.7 мянган төгрөгөөр,
- Бусад орлого 13,514.9 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- ✓ **ХХОАТ:** Цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой,
- ✓ **Үйл ажиллагааны орлого:** Иргэдийн орлого болон төрөөс иргэдэд үзүүлж буй өмнөх оны урамшууллын мөнгө нэмэгдсэнтэй холбоотой,
- ✓ **Хөрөнгө борлуулсны орлого:** Иргэдийн үл хөдлөх хөрөнгийн борлуулалт нэмэгдсэнтэй холбоотой,
- ✓ **Үл хөдлөх хөрөнгийн албан татвар:** Өмнөх оны авлага барагдсантай холбоотой.

Тасарсан орлогууд:

- ✓ **Малын тоо толгойн албан татвар:** Татвар хураалтын ажил муу байгаатай холбоотой,
- ✓ **Бууны албан татвар:** Иргэд цагдаа дээр бугаа хасалт хийлгэсэн боловч татварын байгууллагад хасалтаа хийлгэдэггүйтэй холбоотой,
- ✓ **Ан, амьтны нөөц ашигласны төлбөр:** Иргэд ан, амьтан агнах зөвшөөрөл бага авснаас шалтгаалан,
- ✓ **Түгээмэл тархацтай ашигт малтмал:** Орлогын төлөвлөлтийг үндэслэл муутай тооцсоноос тасарсан,
- ✓ **Улсын тэмдэгтийн хураамж:** Орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөснөөс тасарсан,
- ✓ **Хог хаягдлын үйлчилгээний хураамж:** Айл өрхөөс хог хаягдлын хураамжийг бүрэн төвлөрүүлдэггүйгээс шалтгаалсан.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 9,859,309.3 мянган төгрөгөөр тооцсон байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 55 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 9,204,694.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 46,000.0 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 786,350.8 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 903,224.5 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 202,100.0 мянган төгрөг нийт орлогыг 11,142,370.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 09–ний өдрийн 79 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 9,350,467.6 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн

үйл ажиллагааны орлогыг 46,000.0 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 786,350.8 мянган төгрөг, ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,056,070.8 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 202,100.0 мянган төгрөг зэрэг нийт **11,440,989.2** мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, **9,004,004.9** мянган төгрөгийг зарцуулж, **2,436,984.3** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 7,688,576.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 797,134.8 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 63,885.4 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 112,409.4 мянган төгрөг зэрэг нийт **8,992,277.9** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **8,317,100.7** мянган төгрөг буюу 92.5 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал **48,427.6** мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 8,026.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 169,106.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 2,074.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 1,578.1 мянган төгрөгөөр, томилолтын зардал 12.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 12,797.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 14,503.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 419,537.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Сумын хөрөнгө оруулалтаар нийт 30 төсөл, арга хэмжээнд 2,032,497.2 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 1,818,036.9 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 214,460.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй он дамжсанаас шалтгаалсан байна.

Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр нийт 13 төсөл, арга хэмжээнд 1,104,392.7 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 899,315.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 178,796.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл, огт хэрэгжээгүй, малын тоо толгойн албан татварын орлого бүрдээгүйн улмаас 1 ажил арга хэмжээ огт хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т *“нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”* гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 3,750.0 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 3,305.5 мянган төгрөг, БОАЖГ-аас 39,400.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 17,884.5 мянган төгрөг зэрэг нийт **67,040.0** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 1,800.0 мянган төгрөг, нормативт зардалд 900.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 44,310.3 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 29.7 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 20,000.0 мянган төгрөг зэрэг нийт **67,040.0** мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Сүхбаатар сумын ОНХО-ын хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан 1,783,821.7 мянган төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан 634,575.4 мянган төгрөгийн 8 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зэрэг нийт 46 удаагийн цахим тендерийн урилгыг tender.gov.mn цахим хуудсанд нийтэлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль стандартын дагуу хөтөлж байх зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/111 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн

үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 6,356,365.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 63,563.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- *Батлагдсан төсвийг 7.5 хувиар хэмнэсэн,*
- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*
- *Албан хаагчдын гар утасны зардал гаргаагүй, сонин хэвлэл захиалаагүй,*
- *Үндэсний баяр наадмаас бусад баяр ёслол, ойн арга хэмжээнд төсвөөс хөрөнгө зарцуулаагүй,*
- *Тус ТТЗ-ийн харьяаны байгууллагуудын эзэмшлийн 2 авто машинд тусгай дугаар авсан гэх мэт.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	148	3	-
2	Засаг даргын Тамгын газар	151	134	5	12
3	Бэлчир бүсийн сум дундын ойн анги	151	143	8	-
	Нийт дүн	453	425	16	12

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 453 мэдээллээс 425 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол огт мэдээлээгүй 12 мэдээлэл байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. ЗДТГ нь шууд худалдан авах босго үнээс давсан 46,100.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна. Энэ нь 2023 оны 6 дугаар сард батлагдсан ТБОНӨХБАҮХАТ хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйлийн 10.2 дахь “...*нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно*”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтын 2 дахь “*Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: бараа – 20.0 сая төгрөг, ажил – 20.0 сая төгрөг*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд босго үнийн журмыг баримтлах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “*Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай*” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус ТТЗ-ийн 2023 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн тодотгол хийсэн, өглөг авлага үүсгэсэн, үндэслэлгүйгээр хөрөнгө акталсан, анхан шатны баримтын бүрдүүлэлт, төлбөрийн цахим баримт, шилэн данстай холбоотой нийт 351,878.8 мянган төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага, зөвлөмж өгөгдсөнөөс өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	4	262,608.0	4	262,608.0	100.0
Зөвлөмж	5	163,929.8	4	140,811.8	80.0
Хариуцлага тооцуулах албан шаардлага	2	-	2	-	100.0
Нийт дүн	11	426,537.8	10	403,419.8	93.3

Өмнөх аудитаар өгсөн холбогдох анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг уг аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн” болон “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **5,540.8** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дансанд 4,620.0 мянган төгрөгийн бараа материал бүртгэсэн,

2. ЗДТГ нь бараа материалын тайлангийн эхний үлдэгдлийг зөрүүтэй тайлагнаснаас санхүүгийн байдлын тайлан 920.8 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн,

Шийдвэрлэсэн нь: 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өглөө.

Аудитаар нийт **116,761.9** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,950.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 36,301.9 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 78,510.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт:

1. Албан хаагчдын албан томилолтоор ажилласан хугацаанд **1,500.0** мянган төгрөгийн /сумын ЗДТГ 1,310.0 мянган төгрөг, сумын ИТХ нь 190.0 мянган төгрөг/ хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Сумын ИТХ нь төлөөлөгчдийн хоолны зардлыг бодит ирцээр бус нийт төлөөлөгчдийн тоогоор тооцож, **450.0** мянган төгрөг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн хоолны зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

Сумын ТТЗ:

1.Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн *“3,5,6 дугаар багт шороон зам сайжруулах”* төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч Сэлэнгэ есөн эрдэнэ ХХК-д **13,881.9** мянган төгрөг илүү шилжүүлж, авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Сумын ОНХС-аас санхүүжүүлсэн баяр наадмын зардлын батлагдсан төсвийг **2,420.0** мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь *“Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс анхан шатны баримтын бүрдэл дутуу дараах ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл, тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”*, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”*-ын 3.8, Сангийн сайдын 2017

оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ЗДТГ нь ЖМС-аар бэлэн мөнгө хүссэн өргөдөл, олгохыг зөвшөөрсөн албан тушаалтны гарын үсэг, зарцуулалтын тайлангүй **2,770.0** мянган төгрөгийн,
- Жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт зэрэг үзүүлэлтүүдийг бүрэн хөтлөлгүйгээр нийт **2,560.0** мянган төгрөгийн шатахуун зарцуулсан,
- Сургалт зохион байгуулах гэрээ болон гүйцэтгэлийн тайлангүйгээр **3,850.0** мянган төгрөгийн сургалтын зардал гаргасан,
- Үнэ өртөг, хийгдэх ажлын төсөвгүйгээр ЗДТГ-ын байрны урсгал засварт **5,150.0** мянган төгрөг зарцуулсан,
- ИТХ нь гүйцэтгэсэн ажлын тайлан, нотлох баримтгүйгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас “Аз жаргалтай гэр бүл”, “Амар тайван хот” арга хэмжээнүүдийн **5,670.0** мянган төгрөгийн зарцуулалт гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж:

1. Эд хөрөнгийн тооллого, түүний шийдвэрлэлттэй холбоотой

1.1. Илрүүлэлт: Аж ахуйн нэгж байгууллагуудтай тухай бүр гэрээ байгуулан хоол хүнс, бичиг хэрэг, барилгын засварын материалыг худалдан авч, зарцуулсан боловч жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, жилийн эцэст эд, хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын явц, үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, байгууллагын удирдлагад танилцуулж батлуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1:жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “ ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулж, удирдах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт БМ-8-дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагуудтай санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо нийлсэн актаар үлдэгдлийг баталгаажуулж, тооллого, тооцоог хуульд заасан хугацаанд бүрэн гүйцэтгэж байх зөвлөмж өгөв.

2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд нийт 5,460.0 мянган төгрөгийн бараа материалыг тухай бүр бичсэн шаардах хуудсаар бус сар бүрийн эцэст бөөн дүнгээр орлого авч, зарлагадсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр баримтжуулан бүртгэж байх зөвлөмж өгөв.

3. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

3.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **32** нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг ашиглах бол дахин үнэлэх буюу актлах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

4. ЖМС-ийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Сумын ЗДТГ нь ЖМС-аар нийт 29,000.0 мянган төгрөгийг дамжуулан зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 6.1 дэх “Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ(ЖМС) нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс (ЖБТ) хамааран дараах хэмжээтэй байна. Үүнд: ЖБТ 1,000,000,000 төгрөгөөс дээш -ЖМС 1,500,000 - 3,000 000 төгрөг” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөв.

5. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Сүхбаатар сумын ЗДТГ-ын албан конторын /ЗДТГ-ын дотор засварын ажилд 19,900.0 мянган төгрөг, ЗДТГ-ын Б корпус засварын ажилд 19,000.0 мянган төгрөг, ЗДТГ-ын подвалын засварын ажилд 2,300.0 мянган төгрөг, ЗДТГ-ын өрөө тасалгааны цонхны засварын ажилд 2,850.0 мянган төгрөг/ **44,050.0** мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын шинж чанартай их засварын ажлыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд бус төсвийн урсгал зардлын урсгал засварын төсөвт төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”: 5.1.2: “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын 21-Урсгал зардал², 210604-Урсгал засвар³, 22-Хөрөнгийн зардал⁴ гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг холбогдох арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар төлөвлөж, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг ханган ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5⁵-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² 21-Урсгал зардал-Тухайн тайлант жилд байгууллагын болон хөтөлбөр, арга хэмжээний хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах жил бүр давтагддаг урсгал шинжтэй зардлыг энэ ангилалд бүртгэнэ.

³ 210604-Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна.

⁴ 22-Хөрөнгийн зардал-Тухайн төсвийн жилд төсвийн хөрөнгөөр үл хөдлөх хөрөнгө бий болгох, барилга, байгууламж, тоног төхөөрөмж худалдан авах, барилга байгууламжид их засвар хийх, стратегийн шинжтэй бараа, бүтээгдэхүүнийг улсын нөөцөд байршуулахтай холбоотой зарцуулах зардлууд энд багтана.

⁵ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	5,540.8			2	5,540.8			2	5,540.8	2	5,540.8
Дүн	2	5,540.8			2	5,540.8			2	5,540.8	2	5,540.8

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сүхбаатар сумын ТТЗ	10	116,761.9	2	1,950.0	3	36,301.9	5	78,510.0				
Дүн	10	116,761.9	2	1,950.0	3	36,301.9	5	78,510.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нийт 16 мэдээллийг хугацаа хоцроож, 12 мэдээллийг мэдээлээгүй.								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах босгон давсан зардалд тендер зарлаагүй.								
Дүн								
Нийт дүн								